



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 14 сарын 18 өдөр

Дугаар 05

Ханх сум

┌ 2024 оны төсөв батлах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “б” дахь заалт, 48 дугаар зүйлийн 48. “Төсвийн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.4, 57 дугаар зүйлийн 57.3, 58 дугаар зүйлийн 58.4, 64 дүгээр зүйлийн 64.1.2, 64.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Ханх сумын 2024 оны төсвийн орлогын нэр төрлийн хэмжээ болон сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

Д/д	Орлого	Батлагдсан сумын орлого
1	2	3
	Урсгал орлого	367796.1
	Сумын татварын орлого	364796.1
1.	Цалин, хөдөлмөрийн хөлс	216000.0
2.	Үйл ажиллагааны орлого	4500.0
3.	Хөрөнгө борлуулсны орлого	2000.0
4.	Шууд бус орлого	500.0
5.	2022 оны буцаан олголт	0
6.	Хөрөнгийн орлого	17,000.0
7.	Бууны албан татвар	1300.0
8.	Малын тоо толгойн албан татвар	10000.0
9.	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	14,000.0
10.	Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	7392.6
11.	Улсын тэмдэгтийн хураамж	3500.0
12.	Түгээмэл тархац	500.0
13.	Хог хаягдлын хураамж	1106.0
14.	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	560.0
15.	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	997.5
16.	Ойн нөөц ашигласны төлбөр	51000.0
17.	Газрын дуудлага худалдаа	5000.0
18.	Газрын төлбөр	30000.0

6707001034

	Сумын төсвийн татварын бус орлого	3000.0
19.	Хүү, торгуулийн орлого	3000.0

2.Сумаас 2024 онд аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

Д/д	Орлого	Анх батлагдсан сумын орлого
	2	3
	Аймгийн төсвийн орлогын дүн	9500.0
	Аймгийн татварын орлого	9500.0
1.	АТБӨЯХ-ийн албан татвар	8000.0
2.	Зам ашигласны төлбөр	1500.0

3.Аймаг болон сумын төсвөөс 2024 оны төсвийн жилд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн болон орон нутгийн төсвөөс санхүүжих байгууллагуудын төсөв, санхүүжих эх үүсвэрийн төрөл, хэмжээг дор дурдсанаар баталсугай.

Д/д	Байгууллагын нэр	Нийт дүн	Үүнээс:	
			Орон нутгийн төсвөөс	Санхүүгийн дэмжлэг
1	Ерөнхий боловсролын сургууль	124000.0		124000.0
2	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	38500.0		38500.0
3	Соёлын төв	15860.4	15860.4	
4	Засаг даргын тамгын газар	886991.8	309785.1	577206.7
5	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	158310.2	5330.6	152979.6
6	Эрүүл мэндийн төв	26820.0	26820	
	Нийт	1250482.4	357796.1	892686.3

4.Сумын 2024 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг дор дурдсанаар баталсугай:

4.1.Сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 892686.3 мянган төгрөг

4.2.Сумын төсөвт аймгийн төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг 205180.4 мянган төгрөг

4.3.Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 227029.3 мянган төгрөг

4.4.Сумын татварын болон татварын бус орлого 367796.1 мянган төгрөг хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлт"-ийг нэгдүгээр хавсралтаар, 2023 оны шилжих хөрөнгө оруулалт, 2024 онд шинээр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт хоёрдугаар хавсралтаар, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх ажлын жагсаалтыг гуравдугаар

хавсралтаар, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөгдөх зээл, хүүгийн орлого, тухайн онд олгох зээлийн хэмжээ, үйл ажиллагаанд ашиглах зардлын хэмжээг дөрөвдүгээр хавсралтаар, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тавдугаар хавсралтаар, малын тоо толгойн албан татварын зарцуулалтыг зургаадугаар хавсралтаар, тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн төсвийн байгууллагын зарлагын сарын хуваарийг долоо дугаар хавсралтаар тус тус баталсугай.

5.Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр нь бүрэн биелүүлэх, зардлын хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, жилийн эцэст өр, авлагагүй ажиллах, төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны төсөв захирагч нарт даалгасугай.

6.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1, 51.2 дахь заалтын хэрэгжилтийг ханган гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлыг төсөвтөө тусгахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

7.Орон нутгийн орлогын төлөвлөгөөг тасалсан, төсвийн үр ашиггүй зарлага гарган төсвийн хэтрэлт, өр, авлага үүсгэсэн бүх шатны төсөв захирагч нарт төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг тооцон ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагчид даалгасугай.

8.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /К.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

ДАРГА



М.ОЮУНБАТ